



Н. Батсүрэг

*Засагчийн хөгжлийн
хамрагч, хяналт тавьж,
үүр дүнг тайланын
засаг даргын захирамж*

**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар A/87

Эрдэнэт

Одурхад 2022.03.01

**Г Т
Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42.1.3, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.7, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит VI хуралдааны 06/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийн тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Зардалд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлын Боловсрол, эрүүл мэнд, соёл, спортын олон нийтийн арга хэмжээг жилийн турш зохион байгуулах зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Бямбацэцэг)-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үүр дүнг тайлagnаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ) -д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Бумансор)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 07-ны өдрийн
A/87 дугаар захирамжийн хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, ТЭДГЭЭРИЙН ЭЦЭГ ЭХ,
АСРАН ХАМГААЛАГЧ НАРТ ЗОРИУЛСАН ХАМТ ОЛОНД
ТУШИГЛЭН ХАМРУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл:

Орхон аймагт өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 3841 иргэд байгаагаас 413 нь хүүхдүүд байна. Эдгээр хүүхдийн 75-80% нь амьдралын түвшин доогуурт үнэлэгддэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлж, амьдралын чанарыг сайжруулахад асран хамгаалагч, эцэг эх, гэр бүл, анхан шатны байгууллагынхан онцгой үүрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьдралын ихэнх хугацаа нь гэр бүлд өрнөдөг учир гэр булийн уур амьсгал чухал бөгөөд өөрт нь тохирсон сургалтад хамруулах, эмчилгээ, үйлчилгээ авах зэргээр хүүхдийг нийгмийн харилцаанд оруулснаар хөгжих боломж нээгддэг билээ. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан хамт олонд тушиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг үс засалтын салоны хамт олонтой хамтран зохион байгуулахаар найман өрхийн эрүүл мэндийн төвүүдээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нэгдсэн мэдээллийн судалгааг авч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч нараас үс засалтын салонд хамрагдах хэрэгцээний судалгааг гарган дүгнэж, хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсрууллаа.

Хоёр. Зорилго:

Зорилтод бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч нарт Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аж ахуй нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд тусlamж дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах, үйлчилгээг үзүүлэгчдэд ээлтэй, тав тухыг хангасан орчинд мэргэжлийн үс засалт, үс арчилгааны үйлчилгээг үзүүлэх

Гурав. Зорилт:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэртээ харж ханддаг эцэг эхчүүдийн сэтгэл санааг дээшлүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгмийн харилцаанд оролцуулах
- Халдварт хамгааллын дэглэмийг баримталж, цагийн хуваарийн дагуу чанартай үйлчилгээг үзүүлэх
- Үйлчилгээ авч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч нарт эрүүл мэндийн талаарх мэдээлэл зөвлөгөө өгч, эрүүл мэндийн боловсрол болон гоо зүйн мэдлэгийг дээшлүүлэх

Гурав. Хамрах хүрээ:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагчид

Дөрөв. Үйл ажиллагааны хөтөлбөр

№	Хийгдэх ажил	Хугацаа
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нэгдсэн судалгааг гаргах	2 дугаар сарын 28
2	Зорилтод бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг үс засалт, үс арчилгааны салонаар үйлчлүүлэх хуваарь гаргах	2 дугаар сарын 28
3	Нээлтийн үйл ажиллагаа	3 сарын сарын 7
4	Бүртгэл хийх	2 дугаар сарын 28-ны өдрөөс 3 дугаар сарын 18 хүртэл
5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг, эх болон асран хамгаалагчдыг үс засалт, үс арчилгааны салонаар үйлчлүүлэх, зөвлөгөө өгөх үйлчилгээг зохион байгуулах	3 дугаар сарын 07-ны өдрөөс 3 дугаар сарын 18 хүртэл
6	Асран хамгаалагч, эцэг эхчүүдэд эрүүл мэндийн талаар сургалт зохион байгуулах	3 дугаар сарын 07-ны өдрөөс 3 дугаар сарын 18 хүртэл

ОО

Аймгийн Засаг даргын 2022 оны
13 дугаар сарын 21-ны өдрийн
11/27 дугаар захирамжийн II хавсралт

ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Нэр төрөл		Хүний тоо	Нэг бурийн үнэ	Нийт үнэ
1	Үс засалт, үс арчилгаа салоны үйлчилгээ	13-аас доош насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч нар	124	5.500	682.000
		13-аас дээш дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч нарт	150	8.800	1.320.000
Нийт дүн					2.000.000

OO